



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/462

Хэрлэн сум

Түүх соёлын хосгүй үнэт дурсгал болох  
Сэцэн ханы тамга, Сэцэн ханы тамганы  
хайрцгийг зөөж, тээвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралтын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингис хаан музейн үзүүллэгийн танхимын үйл ажиллагааг нээх бэлтгэл ажлыг хангах зорилгоор аймгийн Музейгээс түүх соёлын хосгүй үнэт дурсгал “63-8 хувийн дугаартай Сэцэн ханы тамга”, “63-3 дугаартай Сэцэн ханы тамганы хайрцаг” нийт 2 ширхэг үзмэрийг 3 сарын хугацаатай Чингис хаан музейн байр луу зөөж, тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Музейн дарга (Н.Нямсүрэн)-д даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ